



ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохиролцогч Талууд" гэх/,

Хоёр улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэн;

Хоёр улсын иргэдийн зорчих нөхцлийг хөнгөвчлөх зорилгоор;

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын иргэн энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болох Хавсралт 1 болон Хавсралт 2-т дурдсан хүчин төгөлдөр бичиг баримтаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэхүү Хэлэлцээрийн зохицуулалтын хүрээнд нэвтрэн орж, гарч, дамжин өнгөрч, мөн түр хугацаагаар оршин сууна.

2 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөхдөө Хэлэлцэн тохиролцогч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу олон улсын иргэний тээвэрт зориулсан хилийн боомтоор нэвтрэнэ.

2. Улсын хилээр нэвтрэхдээ Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын үндэсний хууль тогтоомжид заасан дүрэм, журмыг даган мөрдөх үүрэгтэй.

3 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн Хавсралт 1 болон Хавсралт 2-т дурдсан хүчин төгөлдөр бичиг баримт эзэмшигч Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх болон түр хугацаагаар оршин суухад виз авах шаардлагаас 180 хоногийн хугацаанд гуч (30) хүртэл хоног чөлөөлөгдөнө.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын нутаг дэвсгэрт жуулчлал, бизнес болон албан зорилгоор зорчиход виз авах шаардлагаас 180 хоногийн хугацаанд гуч (30) хүртэл хоног чөлөөлөгдөнө.

3. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт виз авах шаардлагаас чөлөөлсөн хугацаанаас илүү хугацаагаар зорчих хүсэлтэй Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө



Талын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт урьдчилан виз мэдүүлнэ.

4 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр оршин суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар болон Олон улсын байгууллагад томилогдон ажиллах Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат, албан болон тусгай паспорт эзэмшигч иргэд томилогдсон хугацааныхаа туршид Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөхдөө виз авах шаардлагаас чөлөөлөгдөх бөгөөд Хэлэлцэн тохиролцогч Талуудын Гадаад хэргийн яамнаас аккредитаци авна.

2. Энэ зүйлийн 1 дэх заалтын зохицуулалт хүчин төгөлдөр паспорт эзэмшигч гэр бүлийн гишүүд (гэр бүл болон хүүхэд)-д мөн адил үйлчилнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч Талууд аккредитаци авсан иргэдийн жагсаалтыг дипломат шугамаар харилцан мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн Хавсралт 1 болон Хавсралт 2-т дурдсан хүчин төгөлдөр бичиг баримт эзэмшигчдэд болон 3 дугаар зүйлд дурдсан хугацааны виз авах шаардлагын чөлөөлөлт нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын олон улсын бараа болон зорчигч тээвэрлэгч, (ачааны машин, автобус болон нисэх онгоцны) багийн гишүүдэд мөн адил хамаарна.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс онцгой нөхцөл байдал (өвчин болон байгалийн гамшиг зэрэг)-ын улмаас энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд дурдсан хугацаанд гарч амжаагүй бөгөөд тэрхүү нөхцөл байдлыг баримтжуулсан, эсхүл бусад аргаар нотолж байвал тэрхүү улсын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрлийг сунгах хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргаж болно.

7 дугаар зүйл

1. Виз авах шаардлагаас чөлөөлөлт нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэдэд хөдөлмөр эрхлэх эрхийг олгохгүй.

2. Хөдөлмөр эрхлэх, судалгааны ажил, гэр бүлийн эргэн уулзалт, урт хугацаанд оршин суух болон бусад зорилгоор гуч (30) хоногоос урт хугацаагаар зорчих Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд Хэлэлцэн тохиролцогч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу дипломат төлөөлөгчийн болон консулын газраас урьдчилан виз авах үүрэгтэй.

3. Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу гадаадын оюутнуудыг сургах эрхтэй боловсролын байгууллагаас



ирүүлсэн хүчин төгөлдөр бичиг баримттай тохиолдолд тухайн оюутнаас авах визийн хараамжийг хөнгөлж болно.

4. Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт оршин суух хугацааг сунгахдаа Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл

Визийн хураамжийн хэмжээг Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүрийн үндэсний хууль тогтоомжоор тогтооно. Визийн хураамжийг Хэлэлцэн тохиролцогч Талууд харилцан адил байх зарчмыг үндэслэн харилцан тохиролцож болно.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиолцогч Тал тус бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэнийг ямар шалтгааны улмаас гэдгийг мэдэгдэлгүй өөрийн улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох эрхийг, эсхүл оршин суух хугацааг хязгаарлах эрхтэй.

10 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл нийгмийн эрүүл мэндийн асуудлаас хамаарч энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох эрхтэй. Ийнхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох тухай мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа хүргүүлснээс хойш далан хоёр (72) цагийн дараа уг арга хэмжээ хэрэгжиж эхэлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх заалтад дурдсан хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох шийдвэр гаргасан Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг дахин сэргээх тухай мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

11 дүгээр зүйл

1. Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш жар (60) хоногийн дотор Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү Хэлэлцээрийн Хавсралт 1 болон Хавсралт 2-т дурдсан бичиг баримтын загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэ зүйлийн 1 дэх заалтад дурдсан бичиг баримтад өөрчлөлт оруулах, эсхүл шинэ загварыг хэрэглэж эхлэх өдрөөс доод тал нь жар (60) хоногийн өмнө Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дээр дурдсан бичиг баримтын загварыг ирүүлнэ.

12 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн заалтыг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг зөвшилцөх, хэлэлцээ хийх замаар зөв зүйгээр шийдвэрлэнэ.



2. Шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтын хэрэгжилтийг хянах зорилго бүхий Ажлын хэсгийг байгуулж болно. Хэлэлцэн тохиролцогч Талууд дурдсан Ажлын хэсгийг байгуулах тухай хүсэлтээ дипломат шугамаар харилцан хүргүүлнэ.

13 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Протоколд гарын үсэг зурах замаар энэхүү Хэлэлцээрт өөрчлөлт болон нэмэлт оруулж болно. Энэхүү Протокол нь Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна. Хэлэлцээрт оруулж буй өөрчлөлт болон/эсхүл нэмэлт нь энэхүү Хэлэлцээрийн 14 дүгээр зүйлийн эхний хэсгийн дагуу хүчин төгөлдөр болно.

14 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдэлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор 1992 оны Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын дипломат болон албан паспорттой иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү хэлэлцээрийг хугацаагүй байгуулах бөгөөд Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал дипломат шугамаар Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдэх хүртэл хүчин төгөлдөр байна. Энэ тохиолдолд энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Тал дурдсан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаа (6) сарын дараа хүчингүй болно.

Энэхүү хэлэлцээрийг Анкара хотноо 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр монгол, турк, англи хэлээр үйлдэв. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



Хавсралт 1

Иргэд харилцан зорчих тухай хэлэлцээрийн хүрээнд
Монгол Улсын болон Бүгд Найрамдах Турк Улсын иргэд
харилцан визгүй зорчиход шаардагдах хүчин төгөлдөр
бичиг баримтын жагсаалт

Монгол Улсад зорчих Бүгд Найрамдах Турк Улсын иргэд доорх хүчин
төгөлдөр бичиг баримттай байна. Үүнд:

1. Дипломат паспорт
2. Албан паспорт
3. Тусгай паспорт
4. Энгийн паспорт
5. Түр паспорт
6. Нисэх онгоцны багийн гишүүний нислэгийн үнэмлэх /Нисэх багийн хамт
яваа тохиолдолд/
7. Буцах үнэмлэх /Бүгд Найрамдах Турк Улсад буцах тохиолдолд/
8. Далайчны биеийн байцаалтын үнэмлэх



Хавсралт 2

Бүгд Найрамдах Түрк Улсад зорчих Монгол Улсын иргэд доорх хүчин төгөлдөр бичиг баримттай байна. Үүнд:

1. Дипломат паспорт
2. Албан паспорт
3. Энгийн паспорт
4. Нисэх онгоцны багийн гишүүний нислэгийн үнэмлэх /Нисэх багийн хамт яваа тохиолдолд/
5. Буцах үнэмлэх /Монгол Улсад буцах тохиолдолд/
6. Далайчны биеийн байцаалтын үнэмлэх